

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ЫГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийгмийн халамжийн сангаас 2027 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө тэтгэвэр тогтоолгосон 18 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцгийн халамжийн тэтгэврийн эрхийг дуусах хүртэлх хугацаанд хэвээр хадгална.

2 дугаар зүйл.Нийгмийн нийгмийн халамжийн сангаас 2027 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө ахмад настныг асарч байгаа иргэнд олгож байсан тэтгэмжийг сунгах хүртэлх хугацаанд эрхийг хэвээр хадгалж, хугацаагүй тогтоолгосон иргэдийг дахин тодорхойлох хүртэлх хугацаанд хэвээр хадгална.

3 дугаар зүйл.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө сум, хороонд халамжийн нийгмийн ажилтнаар ажиллаж байсан төрийн захиргааны албан хаагчид энэ хуулийн 29.1 дэх хэсэг хамаарахгүй.

4 дүгээр зүйл.Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 5.4.1, 5.4.2, 5.4.3-т заасан хөнгөлөлтийг 2027 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө эрх үүсэн авч байсан ахмадуудад хэвээр хадгална.

5 дугаар зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37.9-д заасан мэргэжлийн хамтарсан зөвлөлийг 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс ажиллуулна.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ